2023 он 02 сар 13 өдөр Дугаар СТА-06/23 Улаанбаатар хот

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

"НОЁН ТӨГРӨГ ХИЙМОРЬ ББСБ" ХХК -ийн удирдлагад

Санхүүгийн Тайлангийн Аудитын Талаарх Тайлан

Дүгнэлт

Бид "НОЁН ТӨГРӨГ ХИЙМОРЬ ББСБ" ХХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

"НОЁН ТӨГРӨГ ХИЙМОРЬ ББСБ" ХХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдал, тухайн тайлант хугацааны санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартуудын дагуу үнэн зөв толилуулагдсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-уудын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа энэ тайлангийнхаа Санхүүгийн Тайлангийн Аудитад хүлээх Аудиторын Үүрэг Хариуцлага гэсэн хэсэгт харуулав. Бид Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөлийн Мэргэжлийн Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Дүрмийг санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой зохих ёс зүйн шаардлагуудын дагуу компаниас хараат бус ба НБЁЗОУСЗ-ийн Дүрэм болон эдгээр ёс зүйн шаардлагуудад нийцүүлэн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Олж авсан аудитын баримт нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай, тохиромжтой гэж итгэж байна.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шүүмжээр аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлууд юм. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн тусдаа дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах Эрх Мэдэл Бүхий Этгээдүүдийн Санхүүгийн Тайланд хүлээх Үүрэг Хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайлагналын олон улсын стандартуудын дагуу эдгээр санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах хариуцлага хүлээх бөгөөд мөн залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланг гаргахдаа удирдлага Компанийн үйл ажиллагааг зогсоох юм уу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудаа гаргахдаа удирдлага тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

Санхүүгийн Тайлангийн Аудитад хүлээх Аудиторын Үүрэг Хариуцлага

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх ул үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлдэг гэсэн нотолгоо болохгүй. Буруу илэрхийлэх явдал нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог.

АОУС–ын дагуух аудитын нэг хэсэг байдлаар бид мэргэжлийн шүүмж ашиглаж аудитын ажлын явцад мэргэжлийн үл итгэх хандлагыг баримтлан ажилладаг.

Бид бусад асуудлуудын дундаас аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа болон аудитын явцад тодорхойлсон дотоод хяналтын аливаа мэдэгдэхүйц доголдлыг багтаагаад аудитын илэрсэн томоохон асуудлуудаар засаглах эрх бүхий этгээдүүдтэй харилцдаг.

Засаглах эрх бүхий этгээдүүдтэй харилцсан асуудлуудаас тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн нөлөөтэй асуудлуудыг тодорхойлж тэдгээр асуудлаа аудитын гол асуудлууд гэж үзэж аудиторын тайландаа тодорхойлдог.

Хүндэтгэсэн,

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ БИЗКОН АУДИТ ХХК BIZCON AUDIT LLC УЛААНБААТАР ХОТ ТТГ4917 Д№ 2704404 Л. ОТГОНБАЯР

"НОЁН ТӨГРӨГ ХИЙМОРЬ ББСБ" ХХК
АУДИТЛАГДСАН БАЛАНС
2022 оны 12 сарын 31

(төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
ХӨРӨНГӨ		
Эргэлтийн хөрөнгө:	**482,881,212.04**	**536,691,650.03**
Бэлэн мөнгө	482,881,212.04	359,187,164.35
Банкинд байршуулсан харилцах		177,504,485.68
Банкинд байршуулсан хадгаламж		
Хэвийн зээл		
Хугацаа хэтэрсэн зээл		
Хэвийн бус зээл		
Эргэлзээтэй зээл		
Богино хугацаат хөрөнгө оруулалтын үнэт цаас		
Урьдчилж төлсөн зардал,тооцоо		
Бусад		
Бусад авлага		
Хэвийн өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө		
Бусад хөрөнгө		
Эргэлтийн хөрөнгийн дүн	**482,881,212.04**	**536,691,650.03**
Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө /цэвэр/		
Үндсэн хөрөнгийн элэгдэл		
Эд хогшил	2,776,300.00	2,776,300.00
Хуримттлагдсан элэгдэл	(2,181,172.52)	(2,393,802.52)
Техник хэрэгсэл	2,267,000.00	2,267,000.00
Хуримттлагдсан элэгдэл	- 2,202,833.35	- 2,239,500.03
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	**659,294.13**	**409,997.45**
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	**483,540,506.17**	**537,101,647.48**
ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ БА ӨР ТӨЛБӨР		
Богино хугацаат өглөг		
Цалингийн өглөг		
ЭМД, НДШ өглөг		
ХАОАТ өглөг		
ОАТ өглөг	88,866.31	536,500.07
Бусад өглөг		
Богино хугацаат өглөгийн дүн	**88,866.31**	**536,500.07**
Урт хугацаат өглөг		
Урт хугацаат зээл		-
Урт хугацаат өглөгийн дүн	-	-
Нийт өр төлбөрийн дүн	**88,866.31**	**536,500.07**
Эзэмшигчийн өмч		
Хувийн өмч	400,000,000.00	400,000,000.00
Нэмж төлөгдсөн капитал		-
Хуримтлагдсан ашиг/алдагдал	83,451,639.86	136,565,147.41
Эзэмшигчдийн өмчийн дүн	**483,451,639.86**	**536,565,147.41**
НИЙТ ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧ БА ӨР ТӨЛБӨР	**483,540,506.17**	**537,101,647.48**

ВИЗИОН АУДИТ

"НОЁН ТӨГРӨГ ХИЙМОРЬ ББСБ" ХХК
ОРЛОГО, ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН
2022 оны 12 сарын 31

(төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
Хүүгийн орлого		
Хугацаандаа байгаа зээлийн хүүгийн орлого		
Хугацаа хэтэрсэн зээлийн хүүгийн орлого		
Харилцах дансны хүүгийн орлого		
Хүүгийн орлогын буцаалт		
Хүүгийн зардал		
Банкны байгууллагаас авсан зээлийн хүүгийн зардал		
Бусад санхүүгийн байгууллагаас авсан зээлийн хүүгийн зардал		
Цэвэр хүүгийн орлого	12,791,054.62	65,946,629.39
Хүүгийн бус орлого	12,791,054.62	65,946,629.39
Гадаад валютын арилжааны орлого	12,739,050.20	63,112,105.60
Гадаад валютын ханшийн тэгштгэлийн орлого	52,004.42	2,834,523.79
Бусад үйлчилгээ		
Хүүгийн бус зардал	3,904,423.94	12,296,621.77
Гадаал валютын ханшийн тэгштгэлийн зардал		
Үндсэн болон нэмэгдэл цалин		
Нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын зардал		
Сургалтын зардал		
Гадаад валютын ханшийн тэгштгэлийн зардал	1,765,125.63	8,234,464.07
Аудитын төлбөр	440,000.00	440,000.00
Түрээсийн зардал		
Ашиглалтын зардал/ цахилгаан, уур ус, дулаан, цэвэр, бохир ус/	101,500.00	640,050.00
Элэгдэлийн зардал	249,296.68	249,296.68
Харуул хамгаалалтын зардал		
Харилцаа холбоо, интернет	178,800.00	124,950.00
Шатахуун болон тээврийн зардал		
Сэлбэг хэрэгсэл засварын зардал		
Зохицуулалтын хураамжын зардал	1,000,000.00	1,000,000.00
Захиалгат хэвлэлийн зардал		
Автоматжуулалттай холбоотой урсгал зардал		
Зар сурталчилгааны зардал		200,000.00
Бичиг хэргийн зардал		
Ариун цэврийн зардал		
Бусад зардал	169,701.63	1,407,861.02
Цэвэр хүүгийн бус орлого/зардлын дүн	8,886,630.68	53,650,007.62
Болзошгүй эрсдэлийн сан байгуулахаас өмнөх үйл ажиллагааны ашиг алдагдал	8,886,630.78	53,650,007.62
Болзошгүй эрсдэлийн зардал		
Үндсэн үйл ажиллагааны ашиг/алдагдал		
Ердийн бус орлого		
Үйл ажиллагааны бус зардал		
Ердийн үйл ажиллагааны ашиг алдагдал	8,886,630.78	53,650,007.62
Татвар төлөхийн өмнөх ашиг, алдагдал	8,886,630.78	53,650,007.62
Орлогын татварын зардал	88,866.31	536,500.07
Цэвэр ашиг/ алдагдал	8,797,764.47	53,113,507.55

2 ВИЗИОН АУДИТ

"НОЁН ТӨГРӨГ ХИЙМОРЬ ББСБ" ХХК
ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН
2022 оны 12 сарын 31

(төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Нэмж төлөгдсөн капитал	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2021 оны 12 сарын 31	400,000,000.0	-	83,451,639.86	483,451,639.86
				-
НББ-ийн өдлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				-
Тайлангийн хугацааны ашиг (алдагдал)	-		53,113,507.55	53,113,507.55
Хувьцаат капиталын өсөлт				-
2022 оны 12 сарын 31	400,000,000.0	-	136,565,147.41	536,565,147.41

ВИЗИОН АУДИТ

"НОЁН ТӨГРӨГ ХИЙМОРЬ ББСБ" ХХК
МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН
2022 оны 12 сарын 31

(төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	Дүн
1. Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн	**53,810,437.99**
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого	**57,712,165.30**
Зээлийн хүүгийн орлого	
Үйлчилгээний хураамж шимтгэлийн орлого	
Банкин дахь хадгаламжийн хүүгийн орлого	
Гадаад валютын арилжааны орлого	63,112,105.60
Гадаад валютын ханшийн зөрүү	(5,399,940.30)
Бусад үйлчилгээний орлого	
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлага	**3,901,727.31**
Үндсэн ба нэмэгдэл цалин	
Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын зардал	
Ашиглалтын зардалд төлсөн мөнгө	640,050.00
Шатахуун холбоо, интернэт сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө	124,950.00
Бичиг хэрэг, ариун цэврийн зардал	
Татвар даатгалын байгууллагад төлсөн мөнгө	88,866.31
Зээл болон түүнтэй холбоотой авлагыг барагдуулахтай холбоотой гарсан зардал	
Зар сурталчилгаанд төлсөн мөнгө	200,000.00
Аудитын төлбөр, мэргэжлийн зөвлөгөө үйлчилгээний мөнгө	440,000.00
Зохицуулалтын үйлчилгээний хураамжид төлсөн мөнгө	1,000,000.00
Бэлтгэн нийлүүлэгчид төлсөн мөнгө	
Бусад үйлчилгээнд төлсөн мөнгө	1,407,861.00
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	
Бусад	
2. Үндсэн бус үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	
Үндсэн бус үйл ажиллагааны мөнгөн орлого	-
Бусад(дүрмийн сан нэмэгдүүлсэн орлого)	
Үндсэн бус үйл ажиллагааны мөнгөн зарлага	-
Бусад	
Үндсэн бус үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-
4. Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	**53,810,437.99**
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	**482,881,212.04**
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	**536,691,650.03**

Гүйцэтгэсэн:

Аудиторын туслах: Б.Дэлгэрмаа

Хүлээн зөвшөөрсөн

ВИЗИОН АУДИТ